



# FIRE



Flagstaff International Relief Effort

*“Тусламжийг хүмүүсийн гарт шууд хүргэнэ”*

[www.fireprojects.org](http://www.fireprojects.org)



# FIRE



Flagstaff International Relief Effort

PO Box 22187  
Flagstaff, AZ 86002  
USA

phone: 1-928-779-228  
fax: 1-928-779-2401

[www.fireprojects.org](http://www.fireprojects.org)

Ш/Х 44 - 870  
Улаанбаатар -14250  
Монгол Улс

Утас: 976-70101810  
Факс: 976-70101810

[info@fireprojects.org](mailto:info@fireprojects.org)  
[www.fireprojects.org](http://www.fireprojects.org)

ФАИР-ын тухай .....1-2

Монгол улс дахь вирус хепатитийн тархалт ба элэгний хорт хавдрын өвчлөл .....3

Бидний үйл ажиллагаа .....4-10

Биднийг сонгох шалтгаан .....11



# ФАИР-ын тухай

ФАИР (Flagstaff International Relief Effort - FIRE) нь АНУ-д 501c.3 бүхий албан ёсны бүртгэлтэй, Аризона мужийн Флагстаф-д төвтэй шашны бус, ашгийн бус, төрийн бус байгууллага юм. ФАИР нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо төлөөлөгчийн газартай бөгөөд Монгол улсад хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний аюулгүй байдал, вируст хепатит ба элэгний хавдраас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд голчлон чиглэгдэж байна.

Эдгээр төсөл хөтөлбөрүүдийг Монгол улсын Засгийн газар, Эрүүл мэндийн Яам (ЭМЯ)-наас баримталж буй стратеги бодлогын хүрээнд ЭМЯ, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ), Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Азийн Хөгжлийн Банк, Канадын Олон Улсын Эрүүл Мэндийн Нийгэмлэг, Стэнфордын Их Сургуулийн Азийн Элэг Судлалын Төв, Олон улсын Ротари Клубууд, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв, Хавдар Судлалын Үндэсний Төв зэрэг байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

ФАИР нь 2015 оны 4 дүгээр сарын 25-ний өдөр Балба улсад болсон хүчтэй газар хөдлөлтийн гамшгийн дараа Гималайн уулсад, далайн түвшнээс дээш 3,810 метрийн өндөрт орших Лангтанг тосгоны ард иргэдийг нүүлгэн шилжүүлэх, яаралтай тусламж дэмжлэг үзүүлэх,

өв соёлыг хадгалах, эдийн засгийн хөгжлийг хангах зэрэг цаашдын тогтвортой байдлыг төлөвлөхөд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

## Эрхэм зорилго

ФАИР ТББ нь соёлын онцлог, өв уламжлал, ёс заншлыг харгалзан хувь хүний үнэ цэнийг дээдэлсэн, олон нийтэд түшиглэсэн хөтөлбөрүүдээр дамжуулан эрүүл мэнд, нийгмийн хөгжлийг сайжруулах эрхэм зорилго бүхий байгууллага юм.

## Алсын хараа

Бид хариуцлагатай хөгжлийг дэмжих тогтвортой эх үүсвэрийг бий болгох, аюулгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар олон нийтийн амьдралын чанарыг сайжруулахаар зорин ажиллаж байна.

## Эрхэмлэх зүйлс

ФАИР нь байгууллагынхаа эрхэмлэх үнэт зүйлсийг тодорхойлон, эдгээрийг аливаа хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх, хамтрагч нартай харилцахад мөрдлөг болгон ажиллаж байна. Эдгээр үнэт зүйлс нь хариуцлага болон хүндлэлийн дээд илэрхийлэл юм.

*Хариуцлагатай байдал* – Хариуцлагыг эрхэмлэн хүлээсэн үр дүн, амлалтандаа хүрэх, товлосон хугацааг баримтлах

*Бүтээмж* – Ашиггүй зардал, үр дүнгүй оролд - логогүйгээр өндөр бүтээмжтэй ажиллах

*Тогтвортой байдал* – Хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээ урт хугацааны туршид үр нөлөөтэй тогтвортой байлгах, тухайн орон нутагт нутагшуулах

*Хамтын ажиллагаа* – Үндэсний болон хамтрагч байгууллагуудтай стратеги бодлогын хүрээнд үр дүнтэй хамтран ажиллах

*Чадавхжуулалт* – Орон нутгийн хүн амыг чадавхжуулах, манлайлахад дэмжлэг үзүүлэх

*Харилцаа холбоо* – Нээлттэй, үнэнч шударга, цагаа олсон, ёс заншил, соёлыг хүндэтгэсэн харилцаа холбоог эрхэмлэх

*Нээлттэй, ил тод байдал* – Байгууллагынхаа үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан мэдээг нээлттэй, ил тод, үнэн зөв мэдээлэх



Тусламжийн хөтөлбөрт хамрагдсан цэцэрлэгийн хүүхдүүд, 2005 он



Казак бүргэдийн анчин, © Дэвид Эдвардс, 1999 он

## Бидний түүх

1990-ээд онд Зөвлөлтийн эдийн засгийн тогтолцоо нуран унаснаар Монгол улс нийгэм эдийн засгийн хүнд цаг үетэй тулгараад байсан юм.

1992 онд ФАИР-ын үүсгэн байгуулагч, фото сурвалжлагч Дэвид Эдвардс нь Монголын амьдрал, соёл, ёс заншилтай танилцан, гэрэл зураг авч эхэлжээ. Тэрээр 1993 онд Флагстаф хотын иргэдийн хандивласан өвлийн дулаан хувцасыг Монголын хүүхдийн асрамжийн газруудад болон орон гэргүй хүүхдүүдэд гараас гарт биечлэн тараан өгчээ. 1997 онд Эдвардс, Дианна Хасэнбанк болон Флагстаф хотын хэсэг оршин суугчидтай хамтран “Монголын Өнчин Хүүхдүүдийн Холбоо” нэртэй тусламжийн байгууллагыг үүсгэн байгуулсан билээ.

Тэд 1999 онд 40 футийн чингэлэг бүхий тусламжийг Монгол орон даяар “гараас гарт” түгээжээ. 2000 онд байгууллагынхаа нэрийг Flagstaff International Relief Effort - буюу ФАИР болгон өөрчлөв. 2003 онд Эдвардсын бизнес менежерээр ажиллаж байсан Мередит Поттс нь ФАИР-ын Гүйцэтгэх захиралаар томилогдсон бөгөөд ФАИР нь 2005 оноос өвлийн хувцас түгээхийн зэрэгцээ эмнэлгийн багаж хэрэгсэл хандивлах болон сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн.



Гараар нэхсэн өвлийн дулаан хувцас хүлээж авсан цэцэрлэгийн хүүхдүүд

ФАИР нь 1999 оноос 2009 оныг хүртэл нийт 15 аймгийн 65,000 иргэдэд 40 футийн багтаамжтай 10 чингэлэг, 76 тонн тусламжийн барааг Америкийн сайн дурын 46 ажилтнуудын оролцоотойгоор гараас гарт хүргэсэн. Мөн ФАИР-ын 23 эрүүл мэндийн сайн дурын ажилтнууд 720,000 ам. долларын өртөг бүхий эмнэлгийн багаж хэрэгслийг 348 эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлж, нийт 1,200 цагийн сургалтанд 2100 эрүүл мэндийн ажилтнуудыг хамрууллаа.



АНУ-ын эрүүл мэндийн сайн дурын ажилтан тусламжийн аяны үеэр, 2005 он

Түүнчлэн 80 ширхэг компьютер болон 6,000 гаруй англи хэлний сурах бичгийг хөдөө орон нутгийн сургуулиудад хандивласан. 2009 оноос нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ урт хугацааны тогтвортой төсөл хөтөлбөрүүд болгон өргөжүүлж, АНУ-ын Эрүүл мэндийн Үндэсний төв, Олон улсын Ротари байгууллагатай хамтран эрүүл мэндийн тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг үнэлэх ба вирүст хепатитаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж эхэлсэн.

Уг төсөл хөтөлбөрүүд нь ФАИР-ын одоогийн хэрэгжүүлж буй вирүст хепатит ба элэгний хорт хавдраас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн эхлэл болсон юм. Бид 2009 оноос өнөөдрийг хүртэл нийт 8 аймгийн 8,526 иргэдэд вирүст хепатит болон элэгний хавдар илрүүлэх иж бүрэн шинжилгээг хийн 78,500 мэдээлэл сурталчилгааны материалуудыг иргэдэд хүргэж, 3,022 иргэдийг В хепатитийн эсрэг дархлаажуулалтанд хамруулсан. Нийт 3,571 эрүүл мэндийн ажилтнуудын дунд эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн талаар сургалтыг явуулж, сургалтын видео 2,000 ширхэг, 155,000 биоаюулгүйн хайрцаг, 1,000,000 ам.долларын өртөг бүхий бусад шаардлагатай хэрэгслүүдээр хангасан.

Мөн цэцэрлэгийн насны 523 хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийн зөвлөгөө өгөв. ФАИР-ын хөтөлбөрүүд нь тухайн нутгийн соёл, ёс заншилыг хүндэтгэсэн, алслагдсан нутгийн хүн амд чиглэсэн байдаг тул бусад улс орнуудад ч хэрэгжүүлж болохуйцаар загварчлагдсан байдаг.

# Монгол улс дахь вирус хепатитийн тархалт ба элэгний хорт хавдрын өвчлөл

Монгол улс нь хепатитийн В, С вирусийн халдварын тархалт өндөр орны нэг бөгөөд элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшингээрээ дэлхийд тэргүүлдэг ба энэ нь дэлхийн дунджаас 6 дахин их байна. Түүнчлэн элэгний хавдартай гэж оношлогдсон хүн амын 84.2% нь хожуу шатандаа буюу III, IV шатандаа оношлогдож, 81.2% нь анх оношлогдсноосоо хойш 1 жил хүртэлх хугацаанд амьдарсан байна.


Элэгний хорт хавдрын шалтгааны 46% хепатитийн С вирус, 35% хепатитийн В вирус, 14% хепатитийн В, С вирусийн хавсарсан халдварын шалтгаантай гэж судлаачид тогтоожээ.

ДЭМБ-тай хамтран хийсэн тооцооллоор манай улсад вирус хепатитийн В, С архаг халдвартай 400 мянган хүн амьдарч байгаа бөгөөд элэгний хорт хавдрын өвчлөл өндөр байгаа нь вирус хепатитийн өвчлөл өндөр байгаатай холбоотой.


Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, В хепатитийн эсрэг дархлаажуулалтанд хамруулах, эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт ба хяналтыг сайжруулах зэрэг замуудаар вирус хепатитийн халдвараас урьдчилан сэргийлэн, вирус хепатитийг эрт илрүүлэн эмчилсэнээр элэгний хатуурал, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулах боломжтой.

Монгол улсын Засгийн газраас хүн амаа вирус хепатитаас сэргийлэх, элэгний өвчнийг эрт илрүүлэх, тандах, оношлох ажилд онцгой анхааран, үндэсний хэмжээний стратеги, хөтөлбөрийг боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлсэний үр дүнд 2020 онд хепатитийн С вирусийн халдварыг бүрэн эмчилж, голомтыг устган, элэгний хавдар, хатуурлын шалтгаантай нас баралтыг эрс бууруулах зорилтыг тавин ажиллаж байна.

1991 оноос В хепатитийн эсрэг вакциныг заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллод нэвтрүүлсэнээр шинээр төрсөн нярай хүүхдүүдийн 97% -ийг төрсний дараах 24 цагийн дотор В хепатитийн эсрэг вакцинд хамруулж, тав хүртэлх насны хүүхдийн дунд В вирус хепатитийн тархалтыг 0.58% хүртэл бууруулсан байна.



(Эх үүсвэр: "Lancet" сэтгүүл, 2011)



MAP 3-5. DISTRIBUTION OF HEPATITIS C VIRUS INFECTION  
\* Disease data source: Mead, Haniffah, K, Greener, J, Fisman, AD, Wiersma ST. "Global Epidemiology of Hepatitis C Virus Infection: New Estimates of Age-Specific Antibody to HCV and Seroprevalence." Hepatology 2013; 57:1333-1342.

Хепатитийн С вирусийн халдварын тархалт, улс орноор

Түүнчлэн хепатитийн С вирусийн эсрэг шинэ эмүүдийг эмийн улсын бүртгэлд бүртгэж, эмчилгээнд нэвтрүүлэн эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлттэй үнээр олгож байгаа нь эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж байна.

Хүн ам цөөн, нийт хүн амын 97% нь бичиг үсгийн боловсролтой, эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалт сайн хөгжсөн зэрэг нь вирус хепатиттай үр дүнтэй тэмцэн, С вирусийн халдварын голомтыг устган, халдварын тархалтыг бууруулсан жишиг орон болох боломжийг бүрдүүлж байна.

# Бидний Үйл Ажиллагаа



## Вирүст гепатит ба элэгний хавдрыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх төсөл

ФАИР нь 2011 оноос “Вирүст гепатит ба элэгний хавдрыг эрт илрүүлэх төсөл”-ийг орон нутгийн хүн амын дунд хэрэгжүүлж ирсэн ба 2016 оны 4-р сард ДЭМБ болон Европын Элэг Судлалын Холбооноос вирүст гепатитийг эрт илрүүлэх шинэ санаачлага бүхий таван төслийн нэгээр шалгарсан.

Уг төсөл нь ДЭМБ-ын “2030 он гэхэд Вирүст гепатитийг устгах” стратегийн зорилт, Монгол улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх зорилготойгоор хэрэгжиж байна.

Төслийн хүрээнд алслагдсан орон нутгийн, эмзэг бүлгийн, эрүүл мэндийн даатгалгүй иргэдэд вирүст гепатит болон элэгний хавдрыг эрт илрүүлэх үзлэг шинжилгээг элэг судлаач, хавдрын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, хэт авиан болон элэгний хатуурлын зэрэг тодорхойлох оношлогооны эмч нарын баг дараах алхамуудаар хүргэдэг.

*Алхам 1.* Зорилтот бүлгийн хүн амыг гепатитийн В, С вирүсийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулна.

*Алхам 2.* Гепатитийн В вирүсийн халдвар илрээгүй иргэдийг сайн дурын үндсэн дээр В гепатитийн эсрэг дархлаажуулалтанд хамруулна.

*Алхам 3.* Гепатитийн В болон С вирүсийн халдварын аль нэг нь илэрсэн иргэдийг элэгний хэт авиан оношлогоонд хамруулна.

*Алхам 4.* Элэгний хэт авиан оношлогоогоор элгэнд бүтцийн өөрчлөлт илэрсэн иргэдийг хавдрын уураг болох альфа-фетопротейн илрүүлэх шинжилгээнд хамруулж, хавдрын нарийн мэргэжлийн эмч үзлэг хийж зөвлөгөө өгнө.

*Алхам 5.* Элэгний хатуурлын эмгэг өөрчлөлт илэрсэн иргэдийг элэгний хатуурлын зэрэг тодорхойлох оношлогоонд хамруулж элэгний нарийн мэргэжлийн эмч зөвлөгөө өгнө.

*Алхам 6.* Гепатитийн В, С вирүсийн халдвартай гэж оношлогдсон иргэдэд элэгний нарийн мэргэжлийн эмч үзлэг хийж зөвлөгөө өгнө. Нарийн мэргэжлийн эмч нь иргэдийн эрүүл мэндийн одоогийн нөхцөл байдал, цаашид шаардлагатай эмчилгээний талаар тайлбарлахаас гадна халдвар дамжихаас урьдчилан сэргийлэх, амьдралын хэв маягаа хэрхэн өөрчилж эрүүл амьдрах зэрэг зөвлөгөөг өгч, шаардлагатай гарын авлагуудаар хангана.

### ***В гепатитийн эсрэг дархлаажуулалт***

В гепатитийн эсрэг вакциныг хийлгэснээр гепатитийн В вирүсийн халдвараас сэргийлэхээс гадна элэгний хатуурал, элэгний хорт хавдар зэрэг хүндрэлүүдээс сэргийлнэ. ФАИР нь 2011 оноос хойш хөдөө орон нутгийн эрүүл мэндийн ажилтнууд болон вирүст гепатит, элэгний хавдрыг эрт илрүүлэх төслийн хүрээнд гепатитийн В вирүсийн халдвар илрээгүй иргэдийг сайн дурын үндсэн дээр В гепатитийн эсрэг дархлаажуулалтанд хамруулдаг.



Шинжилгээ хийлгэхээр цусаа өгч буй байдал



Хэт авиан оношилгоо

## Эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт

Орон нутгийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах нь вирүст хепатит ба элэгний хавдраас урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад нэн чухал юм.

ФАИР нь 2015 оноос ЭМЯ, ДЭМБ-ын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, бодлогын дагуу эрүүл мэндийн ажилтнуудад чадавхжуулах сургалтыг тухайн орон нутагт нь зохион байгуулж байна. Сургалтын агуулга, хөтөлбөрийг ЭМЯ-ны мэргэжил арга зүйн дэмжлэгтэйгээр боловсруулж, оролцогчдод сургалтын багц цаг олгодог ороо давуу талтай.

Сургалт нь танхимын болон гардан үйлдлийн 2 хэсэгтэй. Үүнд:

- Вирүст хепатит болон элэгний хавдрыг эрт илрүүлэх
- Вирүст хепатит, элэгний хавдрын үеийн тусламж үйлчилгээ ба менежмент

Оролцогчид танхимын сургалтаар авсан онолын мэдлэгээ сургагч багш нарын удирдлага дор үзлэг шинжилгээний явцад хэрэглэх нь сургалтыг илүү үр дүнтэй болгож байна. Мөн сургалтын явцад ЭМЯ, ДЭМБ болон бусад холбогдох байгууллагуудаас боловсруулсан удирдамж, гарын авлага, шинэчлэгдсэн тогтоол журам зэргийг хэвлэн тараахаас гадна олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгоход шаардлагатай сургалтын аудио материалуудыг боловсруулан өгдөг нь тэдний цаашдын үйл ажиллагаанд томоохон дэмжлэг үзүүлж байна.

## Эрүүл мэндийн ажилтануудад зориулсан зайны сургалт

Эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах хөтөлбөрийг өргөжүүлэх зорилгоор бид зайны сургалтуудыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Зайны сургалтыг Улаанбаатар хотын эмч нар болон олон улсын зөвлөхүүд интернет орчинд шууд удирдан явуулах боломжтой. Мөн Улаанбаатар хотын эмч нарт зориулан “сургагч багш” бэлтгэх хөтөлбөрийг гадаадын мэргэжилтнүүдийн тусламжтай хэрэгжүүлэн, улмаар эдгээр сургагч багш нар нь хөдөө орон нутгийн эмч нарт орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр шат дараалсан сургалтуудыг явуулж, зөвлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.



Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан танхимийн сургалт



Сургалтын гарын авлага



Цахим сургалтын баннер

## Олон нийтэд чиглэгдсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа

Монгол улсад вирүст хепатит ба элэгний хавдрын өвчлөл, тархалтыг зогсоох нэн тэргүүний алхам нь хүн амын дунд уг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах, эрүүл мэндийн боловсрол олгох юм.

ФАИР нь төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, олон нийтийн байгууллагуудтай хамтран хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийг хамарсан арга хэмжээгээр дамжуулан дараах мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлуудыг явуулдаг.

**Хепатиттай тэмцэх Дэлхийн өдөр** - 2010 оноос ФАИР нь ЭМЯ, ДЭМБ, орон нутгийн Эрүүл мэндийн газруудай хамтран жил бүрийн 7-р сарын 28-нд “Хепатиттай тэмцэх Дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт олон нийтийг хамарсан үзлэг шинжилгээ, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсээр ирсэн.

**Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ** Вирүст хепатит, элэгний хавдрыг эрт илрүүлэх төслийн хүрээнд олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулдаг.

Олон нийтэд чиглэгдсэн сургалт, сурталчилгааг доорх арга хэлбэрээр явуулдаг. Үүнд: телевиз, радиогийн хөтөлбөрүүд, цахим сүлжээ, хэвлэлийн бага хурал зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах; мэдээлэл, сургалт сурталчилгааны материалуудыг тараах; тухайн орон нутгийн ард иргэдийн дунд цуглаан зохион байгуулах гэх мэт.

Түүнчлэн ФАИР нь эрүүл мэндийн ажилтнуудад хүн амын дунд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг цаашид хэрхэн зохион байгуулах, тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар сургалт явуулдаг. Ингэснээр тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллага нь уг үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, хүчин чадалд тулгуурлан бие даан зохион явуулах боломжтой болдог.

### Үндэсний хэмжээний аян

ФАИР нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран вирүст хепатит, элэгний хавдраас урьдчилан сэргийлэх аяныг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төрөл бүрийн бүтээлч, шинэлэг арга барил, үйл ажиллагаагаараа дамжуулан хүн амын дунд уг өвчний тархалтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгохоор ажиллаж байна. Уг аянд зориулан Станфордын Их сургуулийн Азийн Элэгний Төвөөс санаачилсан вирүст хепатит болон элэгний хорт хавдартай тэмцэх дэлхийн хэмжээний аяны бэлэгдэл болох номин туузыг агуулсан өлзий хээг үндэсний аяны бэлэг тэмдэг болгож, “Эрүүл элэг таны амьдрал” хэмээх уриаг хамтрагч байгууллагуудтайгаа хамтран гаргалаа.

### Олон нийтийг манлайлагчид ба бодлого боловсруулагч нарт нөлөөлөх нь

Урт хугацаанд тогтвортой үргэлжлэх, амьдралд нөлөөлөх өөрчлөлтүүд нь салбар хоорондын тогтвортой хамтын ажиллагаа болон тухайн орны засгийн газар, бизнесийн манлайлагч нарын дэмжлэг туслалцааны үндсэн дээр бий болдог. ФАИР нь стратеги бодлого нөлөөллийн хурал зөвлөгөөн, мэдээлэл солилцох уулзалт зэргээр дамжуулан вирүст хепатит ба элэгний хорт хавдрын тархалтын талаарх улсын хэмжээний мэдээллийг орон нутгийн удирдагчид, бодлого боловсруулагчдад хүргэдэг. Ингэснээр тэд удирдлага зохион байгуулалт болон санхүүгийн дэмжлэг туслалцааг үзүүлэх бөгөөд энэ нь үр дүнд суурилсан урт хугацааны хөтөлбөрийг талуудтай хамтран хэрэгжүүлэх шийдлийг бий болгодог.



Олон нийтэд зориулагдсан сургалт, сурталчилгааны самбар



ФАИР-ийн багийн гишүүн олон нийтийн сургалт, сурталчилгааны үеэр ухуулга хийж буй байдал



## Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний аюулгүй байдал

### “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” төсөл

ФАИР нь 2014 оны 7-р сараас Канадын Олон Улсын Эрүүл Мэндийн Нийгэмлэгтэй хамтран ЭМЯ, Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж буй эрүүл мэндийн байгууллагын аюулгүй байдлыг сайжруулах “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 5” төсөлд зөвлөх үйлчилгээний багт бодлого боловсруулах, дэд бүтэц байгууламжийг төлөвлөх, хүний нөөцийг чадавхжуулахад техникийн дэмжлэг тусалцааг үзүүлэн ажиллаж байна. Уг төслийг өвчтөн болон эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдлыг сайжруулан байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны бодлого төлөвлөлтийн хүрээнд хэрэгжүүлж байна. Төсөл дараах 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.

- Цусны аюулгүй байдлыг бэхжүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах
- Эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтыг бэхжүүлэх

Төслийн хүрээнд төсөлд хамрагдах нэгжүүдийг дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах, техникийн дэлгэрэнгүй удирдамж, аргачлалуудыг боловсруулах, боловсон хүчнийг сургаж бэлтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх ба төслийн гол ололт нь сургалтын материал, эмнэлгийн тоног төхөөрөмж, хог хаягдлын менежментийн журмыг олон улсын стандартад нийцүүлэн тогтворжуулах явдал юм.

### Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний стратегийн хэрэгжилтийн хүрээнд ФАИР нь 2009 оноос нийт 12 аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад хог хаягдлын менежмент ба аюулгүй байдлыг сайжруулах төслүүдийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд эрүүл мэндийн ажилтнуудад сургалт явуулж, видео хичээл, зурагт хуудас, товхимолууд зэрэг шаардлагатай гарын авлага материалуудаар хангадаг. Мөн биоаюулгүй хайрцаг, зориулалтын тэмдэг тэмдэглэгээ бүхий уут, хогийн сав зэрэг хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэгслүүдийг нийлүүлдэг.



Эрүүл мэндийн ажилтан нь эмнэлгийн хог хаягдлыг журмын дагуу бус зөөвөрлөж буй байдал



Эрүүл мэндийн ажилтан нь халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг бүрэн өмссөн байдал



Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал, зурагт хуудас



Эмнэлгийн хог хаягдлын сав

## Шүдний эмнэлгүүдийн халдварын сэргийлэлт ба хяналт

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд баримтлах халдварын эсрэг дэглэмийг чанд мөрдөөгүйгээс үүдэн эмнэлгийн орчинд цусаар дамжих халдвар тархах боломжтой.

ФАИР нь эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтыг бэхжүүлэх чиглэлээр 2009 оноос хойш эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн сайжруулах төсөл, 2014 оноос Монгол улсын ЭМЯ, Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 5” төсөлд Канадын Олон Улсын Эрүүл Мэндийн Нийгэмлэгтэй хамтран ажиллаж байна.

Одоогийн байдлаар Монгол улсад шүдний эмнэлгүүдийн халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулах чиглэлээр дорвитой ажил хийгдээгүй байна. ФАИР нь хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүдийн халдварын сэргийлэлт ба хяналтын тогтолцоог бэхжүүлэх цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр орон нутгийн болон олон улсын зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байна.

## Нэмэлт хөтөлбөрүүд

### Эрүүл инээмсэглэл төсөл

Хүн амын шүд, амны хөндийг эрүүлжүүлэх нь хүний биеийн бүхий л эрхтэнд нөлөөлөх байнгын голомтот халдварыг багасган эрүүлжүүлэх нэг чухал хүчин зүйл гэж ДЭМБ-аас үзэж байна. Монгол улсад 2006-2015 онд хэрэгжүүлсэн “Амны хөндийн эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөрт хийгдсэн хөндлөнгийн үнэлгээгээр 6 хүртэлх насны хүүхдүүдийн 83.9%-д шүдний өвчлөл илэрсэн ба тэдгээрийн 90-92%-д эмчилгээ зайлшгүй шаардлагатай байна.

2015 оны 5-р сард ФАИР нь Улаанбаатар Ротари Клуб, АШУҮИС-ийн Нүүр Ам Судлалын Сургууль, НЭМҮТ-тэй хамтран сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах “Эрүүл инээмсэглэл” төслийг хэрэгжүүлсэн ба уг төсөлд Улаанбаатар хотын алслагдсан дүүргийн 5 цэцэрлэгийн хүүхдүүдийг хамруулсан. Төслийн хүрээнд хүүхдийн амны хөндийн үзлэг шинжилгээ хийх, амны хөндийн эрүүл ахуйг сахих талаар сургалт явуулах, мөн сургалтын видео хичээл, гарын авлага товхимолууд, шүдний сойз, шүдээ угаах хэвшлээ хянах хуанли зэрэг сургалтын хэрэгслээр хангах ажлуудыг хэрэгжүүлээд байна.

Мөн эцэг эхчүүдэд сургалт явуулахаас гадна цэцэрлэгүүдийг амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгоход шаардлагатай сургалтын хэрэгслээр хангаж, тэдгээрийг үр дүнтэй ашиглах арга барилыг багш нарт эзэмшүүлсэн нь хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр тогтмол сургалт явуулахад ихээхэн дэмжлэг болсон юм.



Шүдний эмчийн үзлэг



Амны хөндийн эрүүл ахуйн сургалтын үеэр

# Биднийг сонгох шалтгаан



## Шудрага байдал

ФАИР нь эдийн засгийн хүндрэлтэй болон хөгжиж буй орнуудад түгээмэл тохиолддог тэгш бус байдлыг арилгах шударга байдал, шууд оролцооны итгэл үнэмшилд суурилан байгуулагдсан юм. Үүсгэн байгуулагдсан цагаасаа “дундын зуучлагчгүй”, “тусламжийг гараас гарт” уриаг мөрдөн ажиллаж ирсэн бөгөөд шударга байдал, шууд оролцоо нь өнөөдөр ч бидний үйл ажиллагааны гол цөм байсаар байна.

## Санхүүгийн хариуцлага

Монгол улс, Балба улс болон АНУ дахь ФАИР-ын санхүү бүртгэлийн тогтолцоо нь мөнгөний зарцуулалт нэг бүрийг хянахад чиглэн, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг дагаж мөрддөг ба бүх тайлангууд олон нийтэд нээлттэй байдаг. Төлөвлөлтийн сайн менежмент, өндөр хяналт бүхий хөрөнгийн зарцуулалт нь хандивлагчдын хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй ашиглах баталгаа болдог. Тухайлбал 2016 онд нийт орлогын 96%-ийг төслийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

## Эрхэмлэх Зүйлс

Бидний тодорхойлсон эрхэмлэх зүйлс нь ФАИР-ын хэрэгжүүлж буй бүх үйл ажиллагааны ёс зүйн болон ёс суртахууны хэм хэмжээ болдог. Аливаа хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх, хамтрагч нартай харилцах болон дотоод харилцаандаа ч мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн манай байгууллагыг үнэлж дүгнэх гол хэмжүүр нь юм.

## Хамтын ажиллагаа

ФАИР нь амжилт, тогтвортой болон хариуцлагатай байдлаараа нэр хүнд бүхий байгууллага юм. Засгийн газрын гишүүд, орон нутгийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага зэрэг холбогдох байгууллага хувь хүмүүстэй хамтран ажилласнаар тэдэнд нөөц бололцоогоо бүрэн ашиглах болон бүхий л түвшинд харилцан уялдаа бүхий, тогтвортой, үр ашигтай ажиллахад дэмжлэг үзүүлдэг.

## Менежмент

ФАИР-ын мэргэшсэн ажилтанууд болон зөвлөхүүд нь байгууллагынхаа эрүүл мэнд болон ашгийн бус төсөл хөтөлбөрүүддээ арав гаруй жилийн цогц туршлагыг бий болгосон юм.

ФАИР-ын шийдвэр гаргагчид, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай тогтмол харилцаа холбоотой ажилладаг нь төсөл хөтөлбөрийн уялдаа холбоог хангадаг. Мөн хот, хөдөөд ажилласан олон жилийн туршлага нь санхүүгийн нөөц болон цаг хугацааг зөв зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлдэг.

## Олон нийтэд түшиглэсэн

ФАИР тухайн үндэстний соёл, зан заншил, орон нутгийн удирдлагын шийдвэрт хүндэтгэлтэй хандсанаар тогтвортой хөтөлбөрүүдийг урт хугацааны туршид амжилттай хэрэгжүүлэх үндэс болдог. Бид олон нийтийн тулгамдаж буй асуудал хэрэгцээнд тулгуурлан орон нутгийн эмзэг бүлгийн иргэдээс эхлэн засаг захиргааны удирдлага хүртэлх бүхий л түвшинд хамтран ажилладаг.

## Шинэ санаачилга

Бид тулгамдсан асуудлыг бүрэн шийдвэрлэх, орон нутгийн шийдвэр гаргагчдыг чадавхижуулахад чиглэсэн олон талт, цогц, алсын хараа бүхий хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр нь алслагдсан орон нутгийн, тусламж үйлчилгээнд хамрагдах боломжгүй иргэдэд чиглэгддэг. Манай төсөл хөтөлбөрүүд нь тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлага, нөөц бололцоонд зохицон өөрчлөгдөх боломжтой, уян хатан байдаг.

2016 оны 4-р сард ФАИР-ын санаачилсан “Вирүст хепатит ба элэгний хавдрыг эрт илрүүлэх” төсөл нь ДЭМБ болон Европын Элэг Судлалын Холбооноос вирүст хепатитийг эрт илрүүлэх шинэ санаачилга бүхий таван төслийн нэгээр шалгарсан.

*“May good deeds spread.”*

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

**FIRE**



Flagstaff International Relief Effort

*PO Box 22187  
Flagstaff, AZ 86002  
USA*

*phone: 1-928-779-228  
fax: 1-928-779-2401*

*[www.fireprojects.org](http://www.fireprojects.org)*

*Ш/Х 44 - 870  
Улаанбаатар -14250  
Монгол Улс*

*Утас: 976-70101810  
Факс: 976-70101810*

*[info@fireprojects.org](mailto:info@fireprojects.org)  
[www.fireprojects.org](http://www.fireprojects.org)*